



## БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

### САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БӨА-2022/73/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Өлгий хот

2022 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 70422954

Цахим хаяг: [Khuanganm@audit.gov.mn](mailto:Khuanganm@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930

Цахим хаяг: [jenisbekh@audit.gov.mn](mailto:jenisbekh@audit.gov.mn)

Аудитор: К.Риза

Утас: 94156768

Цахим хаяг: [Kalim\\_riza@yahoo.com](mailto:Kalim_riza@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	2
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1 Ерөнхий зүйл.....	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	11
3.4 Материаллаг байдал .....	12
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал .....	14



**БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

НОГООННУУР СУМЫН ЕБ-ЫН  
4 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
А.КҮЛИМХАН ТАНАА

᠒᠐22.02.25 № ᠒᠐8  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>20369855.00</u></b>	<b><u>15017740.00</u></b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	0.00	0.00
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	6404988.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6404988.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	13964867.00	15017740.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	13278867.00	14331740.00
35420	Аж ахуйн материал	9538253.00	10223453.00
35440	Түлш, шатах тослох материал	269500.00	79222.00
35460	Хүнсний материал	3192114.00	3750065.00
35470	Бусад хангамжийн материал	279000.00	279000.00
35600	Мал амьтад	686000.00	686000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>83272715.80</u></b>	<b><u>65167298.46</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	83272715.80	65167298.46
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	75353115.80	57247698.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	92293084.79	92293084.79
39202	Хуримтлагдсан элэгдэл	-38095731.98	-52949611.94
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	27796541.00	27796541.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-21242404.92	-22594344.84
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17768018.00	17768018.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-10992001.27	-12891598.73
39214	Бусад үндсэн хөрөнгө	2335445.00	2335445.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-2335445.00	-2335445.00
39216	Дуусаагүй барилга, байгууламж	0.00	0.00
39217	Ном	7825610.18	7825610.18
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	7919600.00	7919600.00
39301	Програм хангамж	206256.00	206256.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-206256.00	-206256.00
39303	Бусад биет бус хөрөнгө	7919600.00	7919600.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>103642570.80</u></b>	<b><u>80185038.46</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>0.00</u></b>	<b><u>0.00</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>103642570.80</u></b>	<b><u>80185038.46</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	103642570.80	80185038.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	61302173.00	61302173.00
51101	Өмч: - төрийн	61302173.00	61302173.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-32310862.37	-55768394.71
51210	Өмнөх үеийн үр дүн	-32310862.37	-32310862.37
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-23457532.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74651260.17	74651260.17
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>103642570.80</u></b>	<b><u>80185038.46</u></b>

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>255,434,113.00</b>	<b>231,285,698.00</b>
1E+06	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	4,109,253.00	-
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>251,324,860.00</b>	<b>231,285,698.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	240,320,000.00	223,497,800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	240,320,000.00	223,497,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	4,457,898.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	4,457,898.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	7,021,900.00	3,330,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7,021,900.00	3,330,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3,982,960.00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3,982,960.00	-
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>269,671,400.01</b>	<b>254,743,230.34</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>269,671,400.01</b>	<b>254,743,230.34</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	245,520,514.01	246,048,730.34
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	177,133,916.00	179,013,088.00
210101	Үндсэн цалин	161,046,848.00	165,284,088.00
210104	Урамшуулал	15,732,538.00	9,191,200.00
210105	Гэрээт ажлын хөлс	354,530.00	4,537,800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	23,062,134.00	23,302,000.00
210201	Тэтгэврийн даатгал	17,169,940.00	16,397,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,452,445.00	1,726,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,161,958.00	1,380,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	290,490.00	481,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,987,301.00	3,316,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	8,109,950.00	3,020,290.00
210301	Гэрэл, цахилгаан	864,700.00	1,008,500.00
210302	Түлш, халаалт	7,245,250.00	2,011,790.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4,648,800.00	3,986,688.00

210401	Бичиг хэрэг	529,100.00	127,400.00
210402	Тээвэр, шатахуун	1,842,700.00	2,147,488.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	754,400.00	850,200.00
210404	Ном, хэвлэл	172,500.00	89,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	74,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,276,100.00	772,500.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>7,840,081.00</b>	<b>12,031,749.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93,000.00	101,600.00
210502	Хоол, хүнс	6,229,481.00	11,297,749.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,517,600.00	632,400.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>-</b>	<b>500,000.00</b>
210604	Урсгал засвар	-	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>302,000.00</b>	<b>151,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	302,000.00	151,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>450,000.00</b>	<b>589,100.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	189,100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450,000.00	400,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>23,973,633.01</b>	<b>23,454,515.34</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	4,125,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,778,300.00	1,223,698.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	22,195,333.01	18,105,417.34
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24,150,886.00</b>	<b>8,694,500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>8,665,160.00</b>	<b>8,694,500.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3,982,960.00	-
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4,682,200.00	8,694,500.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,485,726.00	-
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(14,237,287.01)</b>	<b>(23,457,532.34)</b>
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-</b>	<b>-</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(14,237,287.01)</b>	<b>(23,457,532.34)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	61,302,173.00	74,651,260.17	-32,310,862.37	103,642,570.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,302,173.00	74,651,260.17	-32,310,862.37	103,642,570.80
D08	Тайлант үеийн үр дүн			-23,457,532.34	-23,457,532.34
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,302,173.00	74,651,260.17	-55,768,394.71	80,185,038.46

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>251324860.00</b>	<b>231285698.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>251324860.00</b>	<b>231285698.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	240320000.00	223497800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	240320000.00	223497800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	0.00	4457898.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.00	4457898.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	7021900.00	3330000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	7021900.00	3330000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	3982960.00	0.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	3982960.00	0.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>251324860.00</b>	<b>231285698.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>251324860.00</b>	<b>231285698.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>227124574.00</b>	<b>222591198.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	178197574.00	172608100.00
210101	Үндсэн цалин	161882176.00	158879100.00
210104	Урамшуулал	15354200.00	9191200.00
210105	Гэрээт ажлын хөлс	961198.00	4537800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25839400.00	23302000.00
210201	Тэтгэврийн даатгал	18183200.00	16397800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1914100.00	1726000.00

210203	ҮОМШӨ-ний даатгал	1531200.00	1380900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	382800.00	345200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3828100.00	3452100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7021900.00	2830000.00
210301	Гэрэл, цахилгаан	864700.00	1008500.00
210302	Түлш, халаалт	6157200.00	1821500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	4391400.00	3779300.00
210401	Бичиг хэрэг	431600.00	132400.00
210402	Тээвэр, шатахуун	1842700.00	2047500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	752200.00	808900.00
210404	Ном, хэвлэл	282500.00	189100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	74000.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1008400.00	601400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	9156500.00	12747100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	93000.00	101600.00
210502	Хоол, хүнс	7216700.00	11981700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1846800.00	663800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	0.00	500000.00
210604	Урсгал засвар	0.00	500000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	302000.00	151300.00
210702	Дотоод албан томилолт	302000.00	151300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	450000.00	589100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	189100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450000.00	400000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	1765800.00	6084298.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	4445400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1765800.00	1638898.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>24200286.00</b>	<b>8694500.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	8714560.00	8694500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	3982960.00	0.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4731600.00	8694500.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	15485726.00	0.00
213301	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	15485726.00	0.00
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	0.00	0.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	265648600.00	231856174.00	226827800.00	226827800.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	265648600.00	231856174.00	226827800.00	226827800.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	260917000.00	227124574.00	218133300.00	218133300.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	191403300.00	178197574.00	172608100.00	172608100.00
210101	Үндсэн цалин	171511300.00	161882176.00	158879100.00	158879100.00
210104	Урамшуулал	15354200.00	15354200.00	9191200.00	9191200.00
210105	Гэрээт ажлын хөлс	4537800.00	961198.00	4537800.00	4537800.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25839400.00	25839400.00	23302000.00	23302000.00
210201	Тэтгэврийн даатгал	18183200.00	18183200.00	16397800.00	16397800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1914100.00	1914100.00	1726000.00	1726000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1531200.00	1531200.00	1380900.00	1380900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	382800.00	382800.00	345200.00	345200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3828100.00	3828100.00	3452100.00	3452100.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5993300.00	7021900.00	2830000.00	2830000.00
210301	Гэрэл, цахилгаан	956300.00	864700.00	956000.00	1008500.00
210302	Түлш, халаалт	5037000.00	6157200.00	1874000.00	1821500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	10696000.00	4391400.00	3779300.00	3779300.00
210401	Бичиг хэрэг	431600.00	431600.00	132400.00	132400.00
210402	Тээвэр, шатахуун	2047500.00	1842700.00	2047500.00	2047500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	820600.00	752200.00	808900.00	808900.00
210404	Ном, хэвлэл	313900.00	282500.00	189100.00	189100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	74000.00	74000.00	0.00	0.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7008400.00	1008400.00	601400.00	601400.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	17170900.00	9156500.00	12747100.00	12747100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	123900.00	93000.00	101600.00	101600.00
210502	Хоол, хүнс	9200200.00	7216700.00	11981700.00	11981700.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7846800.00	1846800.00	663800.00	663800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	500000.00	0.00	500000.00	500000.00
210604	Урсгал засвар	500000.00	0.00	500000.00	500000.00

2107	Томилолт, зочны зардал	588500.00	302000.00	151300.00	151300.00
210702	Дотоод албан томилолт	588500.00	302000.00	151300.00	151300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	763900.00	450000.00	589100.00	589100.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	313900.00	0.00	189100.00	189100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	450000.00	450000.00	400000.00	400000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7961700.00	1765800.00	1626400.00	1626400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7961700.00	1765800.00	1626400.00	1626400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4731600.00	4731600.00	8694500.00	8694500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4731600.00	4731600.00	8694500.00	8694500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	4731600.00	4731600.00	8694500.00	8694500.00
13	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	265648600.00	231856174.00	226827800.00	226827800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	259155300.00	224834274.00	223497800.00	223497800.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	259155300.00	224834274.00	223497800.00	223497800.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	6493300.00	7021900.00	3330000.00	3330000.00
132001	Орон нутгийн төсвөөс	6493300.00	7021900.00	3330000.00	3330000.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	15.00	15.00	15.00	15.00
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	1.00
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	7.00	7.00
620003	Үйлчлэх ажилтан	7.00	7.00	7.00	7.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	4457898.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	4457898.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	4457898.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		4445400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		12498.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	4457898.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.00	4457898.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		4457898.00

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл, гэрээт аудитор К.Риза нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, газрын дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн №03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн эрхэм зорилго нь “Суралцагчдын хэрэгцээнд суурилсан хүртээмжтэй, сургалтын үйл ажиллагаагаар дамжуулан зөв хандлага төлөвшилтэй, бүтээлч, бие даан сурах хүсэл тэмүүлэлтэй болгон хүүхдэд сурган хүмүүжүүлэх, боловсрол эзэмшүүлэх бэлтгэхэд оршино” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 онд тус сургуулийн үйл ажиллагаанд шалгалт хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын дүнгийн 2 хувиар буюу 5.4 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 4.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 23.4 сая төгрөгөөр буюу 22.6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өглөгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	6405,0		(6405,0)
Бараа материал	13964.9	15017.7	1052.8
Үндсэн хөрөнгө	83272.7	65167.3	(18105.4)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>103642.6</b>	<b>80185.0</b>	<b>(23457.6)</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	103642.6	80185.0	(23457.6)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>103642.6</b>	<b>80185.0</b>	<b>(23457.6)</b>

Мөнгөн хөрөнгийн данс оны эхэн болон эцэст үлдэгдэлгүй байна.

Авлага данс оны эхэнд НДШ, цалингийн татвартай холбоотой 6.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан ба тайлант онд авлагаа бүрэн барагдуулсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 15.0 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр нэмэгдсэний дотор хүнсний үлдэгдэл оны эхнээс 0.5 сая төгрөгөөр, аж ахуйн материал 0.7 сая төгрөгөөр нэмэгдэж, түлшний үлдэгдэл 0.2 сая төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 0.1 сая төгрөгийн эм боох материал, 3.0 сая төгрөгийн аж ахуйн материал, 3.9 сая төгрөгийн түлш шатахуун, 20.6 сая төгрөгийн хүнсний материал, 0.1 сая төгрөгийн барилга засварын материал нийтдээ 32.7 сая төгрөгийн бараа материалыг бэлтгэж орлогод авч, 31.6 сая төгрөгийн бараа материалыг үйл ажиллагаандаа зохих зарлагын баримтуудыг үндэслэн зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансанд тайлант онд өөрчлөлт ороогүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 23.4 сая төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 24.1 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд урсгал зардлын санхүүжилтийн хэмжээ өмнөх оноос буурсантай холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос нийт дүнгээр 15.0 сая төгрөгөөр буурсан нь урьд оноос байр ашиглалттай холбоотой зардал 5.1 сая төгрөгөөр, элэгдлийн зардал 4.0 сая төгрөгөөр буурсан болон бусад бараа үйлчилгээний зардлуудын өсөлт, бууралт нөлөөлжээ.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн хуралдааны 16 дугаар тогтоолоор сургуулийн 2021 оны төсвийг 226.3 сая төгрөгөөр баталжээ. Нийт төсвийн 223.0 сая төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 3.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 09-ний өдрийн хуралдааны 41 дүгээр тогтоолоор баталсан төсвийн тодотголоор цалин, НДШ-ийн зардлыг 18.9 сая төгрөгөөр нэмж, нормативт зардлыг 14.4 сая төгрөгөөр, төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлын төсвийг 4.0 сая төгрөгөөр бууруулж тодотгон тусгай зориулалтын дэмжлэгээс авах санхүүжилтийн хэмжээг 0.5 сая төгрөгөөр бууруулж, нийт төсвийг 226.8 сая төгрөгөөр баталсан байна.

Энэ нь анх баталсан төсөвт цалингийн зардлыг 7.5 сая төгрөгөөр дутуу суулгасан, 9.2 сая төгрөгийн урамшлын зардлыг төсөвт суулгаагүй байсантай холбоотой байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 223.5 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 3.3 сая төгрөгийн, нийтдээ 226.8 сая төгрөгийн санхүүжилт авч, батлагдсан төсөвтөө багтаан үйл ажиллагаа явуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 226.8 сая төгрөг буюу 100 хувьтай байна.

Нийт төсвийн 86.4 хувийг цалин, НДШ-ийн зардал, 1.2 хувийг тогтмол зардал, 1 хувийг хангамж бараа материалын зардал, 5.3 хувийг норматив зардал, 3.8 хувийг үдийн цайны зардал, 2.3 хувийг бараа үйлчилгээний бусад зардал тус тус эзэлж байна.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансанд Аймгийн Боловсролын газраас 4.4 сая төгрөгийг нэмэлт санхүүжилтээр олгосныг “Шинэ үе цахим хөтөлбөр”-ийн хүрээнд хөтөлбөрийн бараа бүтээгдэхүүн бэлтгэхэд 3.6 сая төгрөг, сургалтын хөлсөнд 0.3 сая төгрөг, ариутгалын бодис, бичиг хэргийн болон бараа үйлчилгээний бусад зардалд 0.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн бэлтгэж ирүүлсэн 2021 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал ороогүй байна.

Байгууллагын сургалтын үйл ажиллагаа ковидтой холбоотойгоор танхимаар болон цахимаар явагдаж ирсэн ба байгууллагын үйл ажиллагаатай холбоотой тодорхой бус байдал үүссэн тохиолдол гараагүй байна.

АОУС 706.10-д заасан бусад асуудлын хэсэгт тусгахаар аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 701.8-д тодорхойлсон аудитын гол асуудлын хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэхүйц асуудал гараагүй.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ гараагүй байна.

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн горим сорилын дүнгээр үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай зардлуудад цалингийн зардалд 172.6 сая төгрөг, НДШ-ийн зардалд 23.3 сая төгрөг, хүүхдийн хоолны зардалд 11.9 сая төгрөг, үдийн цайны зардалд 8.7 сая төгрөг, түлшний зардалд 3.3 сая төгрөг, нийтдээ **219.8** сая төгрөг зарцуулсан байна.

Тус сургуулийн нийт санхүүжилт 226.8 сая төгрөгөөс үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатай 219.8 сая төгрөгийн зардлыг хасаж 7.0 сая төгрөгийг тэвчиж болох зардал гэж үзээд Засгийн газрын тогтоолын дагуу уг зардлын 10 хувь болох **0.7 сая** төгрөгийг хэмнэх тооцоо гарч байна.

Сургууль нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын дагуу 0.7 сая төгрөгийн хэмнэлт гаргах ёстой байсан тул зөрчилд тооцон албан шаардлага өгөгдөв.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т /шилэн дансны мэдээлэл/ тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Ногооннуур сумын ЕБ-ын 4 дүгээр сургуулийн 2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр шилэн дансанд оруулбал зохих нийт 119 мэдээллийн 117 мэдээллийг хугацаандаа оруулсан, 2 мэдээллийг байршуулаагүй байна. Үүнд:

2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр 2020 оны эцэст 6.4 сая төгрөгийн авлага үүссэн талаархи мэдээллийг, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж хувь 80 хувьтай байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай бүрэн нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын дүнгээр мэдээлбэл зохих мэдээллүүдээс 2 мэдээллийг байршуулаагүй санхүүжилт, төсөв, хөрөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр, арга хэмжээний дүнг өөр үзүүлэлтээр сольж байршуулсан байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаандаа мэдээлсэн байна.

### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 9.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1.3 сая төгрөгийн алдаа зөрчилд залруулга хийж, 0.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 7.1 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлэв.

### **4.1 Залруулсан алдаа**

Үр дүнгийн тайланд хоолны зардлыг 1.3 сая төгрөгөөр илүү, үдийн цайны зардлыг 1.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасныг залруулж, хэрэгжүүлсэн горим, сорилын дүнд үндэслэн Үр дүнгийн тайланд 1.3 сая төгрөгийн залруулга хийлээ.

### **4.2 Төлбөрийн акт**

Акт тогтоогдоогүй

### 4.3 Албан шаардлага

Аудитаар 0.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль нь 2021 онд гүйцэтгэлээр 219.8 сая төгрөгийг үйл ажиллагаандаа зарцуулсан бөгөөд Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1-д зааснаар үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад 7.0 сая төгрөгийн батлагдсан төсвийн 10 хувиар буюу 0.7 сая төгрөгийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал зардлыг төлөвлөн зарцуулаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Тэвчиж болох зардлаас хэмнэлт гаргаагүй 0.7 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгөв.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Бараа материалтай холбоотой асуудал

##### 1.1. Илрүүлэлт:

Тус сургуулийн 2021 оны санхүүгийн байдлын тайланд бараа материалын оны эхний болон эцсийн үлдэгдэлд 686.0 мянган төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байгаа боловч бодит байдлаар тус сургуульд мал байгаагүй гэсэн тайлбарыг сургуулийн захирал, нягтлан бодогч нар өгч байгаа ба оны эцсийн тооллогоор мал тоологдоогүй байна.

##### 1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4 дэхь заалт, 14 дүгээр зүйлийн 14.4.2, 20 дугаар зүйлийн 20.2.6 дахь заалтуудыг мөрдөж, санхүүгийн тайланд үлдэгдэлд байгаа малын асуудлыг шийдвэрлэж, зөрчлийг арилгах.

### Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

#### 1.1. Илрүүлэлт:

2021 оны шилэн дансны тайлангийн дүнгээр өр, авлага үүссэн талаархи 6.4 сая төгрөгийн дүнтэй 1 мэдээлэл, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг оруулаагүй, мэдээлсэн байдлын хэрэгжилтийн дундаж 80 хувьтай байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хууль болон Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын холбогдох заалтуудыг мөрдөн ажиллаж, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Ногооннуур сумын Ерөнхий боловсролын 4 дүгээр сургууль	4	9.1	1	1.3			1	0.7	2	7.1